



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

# Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээл дэх “COVID-19” цар тахлын нөлөө /2021 оны I улирал/

УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,  
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо  
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар  
Утас: (+976) 77121286  
Вэб хуудас: [www.rilsp.gov.mn](http://www.rilsp.gov.mn)

## **АГУУЛГА**

<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	2
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	3
<b>БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....	4
<b>БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ</b> .....	7
АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН .....	7
БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН .....	8
АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА .....	10
АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН .....	12
ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА .....	14
<b>БҮЛЭГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТ</b> .....	16
ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГА .....	16
ДААТГУУЛАГЧ .....	16
ШИМТГЭЛИЙН ОРЛОГО .....	18
АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ .....	19
<b>БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ</b> .....	21

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мянган хүн.....	4
ХҮСНЭГТ 1.2 АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 04-р улирал .....	5
ХҮСНЭГТ 2.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭНИЙ ТОО, сарын эцэст, мянган хүн.....	7
ХҮСНЭГТ 2.2 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, сарын эцэст, насны бүлгээр, 03-р сарын байдлаар.....	8
ХҮСНЭГТ 2.3 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, сарын эцэст, боловсролын түвшин, эзлэх хувиар, 12-р сарын байдлаар.....	8
ХҮСНЭГТ 2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, мянган хүн.....	9
ХҮСНЭГТ 2.5 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, насны бүлгээр, 03-р сар, сарын эцэст .....	9
ХҮСНЭГТ 2.6 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшин, эзлэх хувиар, 03-р сар, сарын эцэст .....	10
ХҮСНЭГТ 2.7 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, сараар .....	10
ХҮСНЭГТ 2.8 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 03-р сар .....	11
ХҮСНЭГТ 2.9 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил мэргэжлийн ангиллаар, 03-р сар .....	11
ХҮСНЭГТ 2.10 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭНИЙ ТОО, сараар.....	12
ХҮСНЭГТ 2.11 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭНИЙ ТОО, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 03-р сар .....	13
ХҮСНЭГТ 2.12 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил мэргэжлийн ангиллаар, 03-р сар .....	13
ХҮСНЭГТ 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО, өсөн нэмэгдэхээр .....	16
ХҮСНЭГТ 3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО .....	16
ХҮСНЭГТ 3.3 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр .....	16
ХҮСНЭГТ 3.4 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр .....	17
ХҮСНЭГТ 3.5 САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр.....	17
ХҮСНЭГТ 3.6 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг.....	18
ХҮСНЭГТ 3.7 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, сангийн төрлөөр, тэрбум төгрөг .....	19
ХҮСНЭГТ 3.8 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВСАН ХҮНИЙ ТОО, өсөн нэмэгдэхээр.....	20
ХҮСНЭГТ 3.9 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, сая төгрөг, өсөн нэмэгдэхээр .....	20

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

ЗУРАГ 1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мянган хүн.....	4
ЗУРАГ 1.2 ХӨДӨЛМӨРИЙН ОРОЛЦОО БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН,.....	6
ЗУРАГ 2.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭНИЙ ТОО, мянган хүн, 3-р сарын байдлаар.....	7
ЗУРАГ 2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭНИЙ ТОО, мянган хүн, 03-р сар .....	9
ЗУРАГ 2.3 ТУХАЙН САРД АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН, сараар.....	12
ЗУРАГ 2.4 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 03-р сар, хувиар.....	14
ЗУРАГ 2.5 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, ажил мэргэжлийн ангиллаар, 03-р сар, хувиар.....	15
ЗУРАГ 3.1 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, мянган хүн.....	17
ЗУРАГ 3.2 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, мянган хүн .....	18
ЗУРАГ 3.3 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг .....	19
ЗУРАГ 3.4 НЭГ ХҮНД ЗАРЦУУЛСАН ДУНДАЖ ХӨРӨНГӨ, сая төгрөг, сараар .....	20

## БҮЛЭГ 1.ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2021 оны 1-р улирлын байдлаар хөдөлмөрийн насны хүн амын 54.9 хувь нь ажиллах хүч, 45.1 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. 2021 оны 1-р улиралд ажиллах хүч 1,156.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 97.0 мянга буюу 7.7 хувиар, өмнөх улирал буюу 2020 оны 4-р улирлаас 60.6 мянга буюу 5.0 хувиар буурсан байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн ам 949.7 мянга болж өмнөх оны мөн үеэс 77.7 мянга буюу 8.9

хувиар, өмнөх улирлаас 31.6 мянга буюу 3.4 хувиар өссөн байна.


### ХҮСНЭГТ 1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мянган хүн

Үзүүлэлт	2019-I	2020-I	2020-IV	2021-I	Өсөлт/Бууралт /өмнөх оны мөн үеэс/	
					Тоо	Хувь
Ажиллах хүч	1 296.7	1 253.1	1 216.7	1 156.1	-97.0	-7.7%
Ажиллагчид	1 143.1	1 170.5	1 124.6	1 054.9	-115.6	-9.9%
Ажилгүй хүн	153.6	82.7	92.1	101.2	18.5	22.4%
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	839.1	872.0	918.1	949.7	77.7	8.9%
Боломжит ажиллах хүч	67.9	82.3	66.1	108.8	26.5	32.2%
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	771.2	789.7	852.0	840.9	51.2	6.5%

Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

2021 оны 1-р улирлын байдлаар ажиллагчид 1,054.9 мянга болж өмнөх оны мөн үеэс 115.6 мянга буюу 9.9 хувиар, өмнөх улирлаас 69.7 мянга буюу 6.2 хувиар буурсан байна. Харин ажилгүй иргэд 101.2 мянга болж өмнөх оны мөн үеэс 18.5 мянга буюу 22.4 хувиар, өмнөх улирлаас 9.1 мянга буюу 9.9 хувиар өссөн байна.

### ЗУРАГ 1.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

2021 оны 1-р улирлын байдлаар ажиллагчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 303.1 мянга (28.7 хувь) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 139.2 мянга (13.2 хувь) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ, 86.3 мянга (8.2 хувь) нь боловсрол, 79.2 мянга (7.5 хувь) нь боловсруулах үйлдвэрлэл, 76.3 мянга (7.2 хувь) нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 60.5 мянга (5.7 хувь) нь барилга, 51.1 мянга (4.8 хувь) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллаж байна.

Доорх хүснэгтэд ажиллагчдын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харууллаа. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын ажиллагчид жил бүр буурсаар байгаа боловч 2021 оны 1-р улиралд өмнөх оны мөн үеэс 45.5 мянга буюу 17.7 хувь, өмнөх улирлаас 12.6 хувиар өссөн байна байна. Харин боловсрол, хүний эрүүл мэнд, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал үйлчилгээний салбарт ажиллагчид өмнөх оны мөн үе болон өмнөх улирлаас буурсан байна.

**ХҮСНЭГТ 1.2 АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 04-р улирал**


Салбар	Өсөлт/Бууралт	
	Өмнөх он	Өмнөх улирал
<b>Бүгд</b>	<b>- 115 568</b>	<b>- 69 677</b>
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	45 486	33 873
Уул уурхай, олборлолт	- 5 344	4 658
Боловсруулах үйлдвэрлэл	- 9 818	- 10 748
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	2 678	- 478
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2 871	3 088
Барилга	- 8 974	- 3 950
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	- 23 732	- 26 473
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	- 23 272	- 15 865
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	946	6 911
Мэдээлэл, холбоо	- 11 784	- 6 883
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	- 4 282	- 8 411
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	- 3 650	- 1 799
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2 059	- 7 284
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1 094	6 220
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	- 16 394	- 5 425
Боловсрол	- 33 756	- 20 816
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	- 22 249	- 8 288
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	- 2 840	- 3 802
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	- 3 893	- 1 861
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	83	- 2 144
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	- 792	- 194

*Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо*

Ажиллах хүчний оролцооны түвшин 2021 оны 1-р улирлын байдлаар 54.9 хувь болж өмнөх оны мөн үеэс 4.1 пунктээр, өмнөх улирлаас 2.1 пунктээр буурсан байна. Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2021

оны 1-р улирлын байдлаар 50.1 хувь болж өмнөх оны мөн үеэс 5.0 пунктээр, өмнөх улирлаас 2.6 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 1.2 ХӨДӨЛМӨРИЙН ОРОЛЦОО БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН,




Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хүн ам 2021 оны 1-р улирлын байдлаар улсын хэмжээнд 216.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 45.9 мянга буюу 26.9 хувиар, өмнөх улирлаас 49.9 мянга буюу 30.0 хувиар өссөн байна.

Ажилгүйдлийн түвшин 2021 оны 1-р улирлын байдлаар 8.8 хувь болж өмнөх оны мөн үеэс 2.2 пунктээр, өмнөх улирлаас 1.2 пунктээр нэмэгдсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 5.0 пунктээр буурсан бол ажилгүйдэл 2.2 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1.3 АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН НИЙЛМЭЛ ТҮВШИН, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо



## БҮЛЭГ 2.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ

### АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН

Ажил хайгч иргэний хөдөлгөөний мэдээнээс харахад 2021 оны 1-р сарын эхэнд 29.9 мянган хүн ажил хайж байсан бол тайлант хугацаанд 6.4 мянган хүн нэмэгдэж, 10.4 мянган хүн хасагдаж сарын эцэст 26.0 мянган хүн болж 3.9 мянган хүнээр буурсан байна. 2021 оны 1-р сарын эхний байдлаар ажил хайгч иргэн 2020 оны мөн үеэс 7.1 мянган хүн буюу 19.1 хувиар буурсан байна. 2021 оны 03-р сарын эхэнд ажил хайгч иргэн 23.3 мянган байсан бол тайлант хугацаанд 8.6 мянган хүн нэмэгдэж, 6.8 мянган хүн хасагдаж, сарын эцэст 25.1 мянган хүн болж 1.8 мянган хүнээр нэмэгдсэн байна. 2021 оны 3-р сарын эцсийн байдлаар ажил хайгч иргэн 25.1 мянга байсан бол өмнөх оны мөн үеэс 6.7 мянга буюу 21.0 хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 2.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭНИЙ ТОО, сарын эцэст, мянган хүн

Он сар	Ажил хайгч /сарын эхэнд/	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард хасагдсан	Ажилд зуучлагдсан	Ажил хайгч /сарын эцэст/
I	29 952	6 446	10 364	1 061	26 034
II	26 034	5 408	8 112	584	23 330
III	23 330	8 573	6 798	1 910	25 105

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 3-р сард ажил хайгч иргэн 8.6 мянгаар нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.5 мянга буюу 21.8 хувиар буурсан байна. Харин тухайн сард ажил хайгч иргэн 6.8 мянгаар хасагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 4.1 мянга буюу 37.5 хувиар буурсан байна. Хасагдсан ажил хаагчдаас 1.9 мянган иргэн ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.1 мянга буюу 6.5 хувиар өссөн байна. 2021 оны 3-р сарын эцсийн байдлаар ажил хайгч иргэн өмнөх оны мөн үеэс 21.0 хувиар буурсан боловч ажилд зуучлагдсан иргэн өмнөх оны мөн үеэс 0.1 мянгаар л өссөн байна. Энэ нь тайлант хугацаанд иргэдийн ажил хайх сонирхол бага байгааг харуулж байна.

ЗУРАГ 2.1 АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭНИЙ ТОО, мянган хүн, 3-р сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 03-р сарын эцэст ажил хайж байгаа иргэдийн 4.0 мянга (15.7 хувь) нь 15-24 насныхан, 9.3 мянга (37.0 хувь) нь 25-34 насныхан, 6.7 мянга (26.5 хувь) нь 35-44 насныхан, 4.2 мянга (16.5 хувь) нь 45-54 насныхан, 0.8 мянга (3.3 хувь) нь 55-59 насныхан, 0.2 мянга (1.0 хувь) нь 60 ба түүнээс дээш насныхан байгаа юм. Ажил хайгч иргэд өмнөх

оны мөн үеэс 6.7 мянгаар буурсны 2.9 мянга (43.0 хувь) нь 15-24 насныхан, 1.6 мянга (23.7 хувь) нь 25-34 насныхан, 1.3 мянга (18.7 хувь) нь 35-44 насныхан, 0.7 мянга (11.1 хувь) нь 45-54 насныхан байна..

ХҮСНЭГТ 2.2 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, сарын эцэст, насны бүлгээр, 03-р сарын байдлаар

Насны бүлэг	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>31785</b>	<b>100</b>	<b>25105</b>	<b>100</b>	<b>-6680</b>	<b>-</b>
15-24	6814	21.4%	3943	15.7%	<b>-2871</b>	43.0%
25-34	10880	34.2%	9296	37.0%	<b>-1584</b>	23.7%
35-44	7908	24.9%	6658	26.5%	<b>-1250</b>	18.7%
45-54	4891	15.4%	4148	16.5%	<b>-743</b>	11.1%
55-59	1005	3.2%	818	3.3%	<b>-187</b>	2.8%
60+	287	0.9%	242	1.0%	<b>-45</b>	0.7%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 03-р сарын эцэст ажил хайгч иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 0.3 мянга (1.3 хувь) нь боловсролгүй, 0.6 мянга (2.4 хувь) нь бага, 1.6 мянга (6.3 хувь) нь суурь, 13.2 мянга (52.6 хувь) нь бүрэн дунд, 1.7 мянга (6.8 хувь) нь техникийн болон мэргэжлийн, 1.2 мянга (4.8 хувь) нь тусгай мэргэжлийн дунд, 6.3 мянга (25.0 хувь) нь дипломын болон бакалаврын дээд, 0.2 мянга (0.8 хувь) нь магистр, докторын зэрэгтэй байна. Өмнөх оны мөн үеэс ажил хайж байгаа иргэн 6.7 мянгаар буурсны 4.4 мянга буюу 66.1 хувь нь бүрэн дунд, 1.0 мянга буюу 14.5 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой хүмүүс байна.

ХҮСНЭГТ 2.3 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, сарын эцэст, боловсролын түвшин, эзлэх хувиар, 12-р сарын байдлаар

Боловсролын түвшин	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>31 785</b>	<b>100</b>	<b>25 105</b>	<b>100</b>	<b>-6 680</b>	<b>-</b>
Боловсролгүй	458	1.4%	336	1.3%	- 122	1.8%
Бага	668	2.1%	593	2.4%	- 75	1.1%
Суурь	1 966	6.2%	1 587	6.3%	- 379	5.7%
Бүрэн дунд	17 613	55.4%	13 200	52.6%	-4 413	66.1%
Техникийн болон мэргэжлийн	2 029	6.4%	1 702	6.8%	- 327	4.9%
Тусгай мэргэжлийн дунд	1 455	4.6%	1 202	4.8%	- 253	3.8%
Дипломын болон бакалаврын дээд	7 244	22.8%	6 278	25.0%	- 966	14.5%
Магистр, доктор	352	1.1%	207	0.8%	- 145	2.2%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээнээс харахад 2021 оны 03-р сарын эхэнд 15.4 мянган бүртгэлтэй ажилгүй иргэн байсан бол тайлант хугацаанд 5.7 мянган хүнээр нэмэгдэж, 4.4 мянган хүнээр хасагдаж, цэвэр дүнгээр 1.3 мянган хүнээр өссөн байна. 2021 оны 03-р сарын эцэст 16.8 мянган бүртгэлтэй ажилгүй хүн байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 мянга буюу 13.5 хувиар буурчээ. Тайлант хугацаанд хасагдсан бүртгэлтэй ажилгүй иргэнээс 24.4 хувь нь ажилд зуучлагдсан байна.


ХҮСНЭГТ 2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, мянган хүн

	Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эхэнд/	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард хасагдсан	Ажилд зуучлагдсан	Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/
I	18 103	4 515	6 146	711	16 472
II	16 472	3 583	4 593	307	15 462
III	15 462	5 676	4 363	1 063	16 775

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 03-р сард бүртгэлтэй ажилгүй иргэний тоо 5.7 мянгаар нэмэгдсэн бөгөөд тухайн сард нэмэгдсэн дүн өмнөх оны мөн үеэс 1.3 мянга буюу 28.5 хувиар өссөн байна. Тухайн сард хасагдсан ажил хайгч иргэний тоо 4.4 мянга болж өмнө оны мөн үеэс 1.3 мянга буюу 23.0 хувиар буурсан байна. Тухайн сард 1.1 иргэн мянган иргэн ажилд зуучлагдсан байна. 2021 оны 01-р сард бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 18.1 байсан боловч 03-р сарын эцэст 16.8 болж 1.3 мянга буюу 7.3 хувиар буурсан дүнтэй байгаа нь хатуу хөл хорионы дэглэмтэй холбоотой байх магадлалтай юм.

ЗУРАГ 2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭНИЙ ТОО, мянган хүн, 03-р сар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2.5 мянга (15.1 хувь) нь 15-24 насныхан, 6.5 мянга (39 хувь) нь 25-34 насныхан, 4.3 мянга (25.8 хувь) нь 35-44 насныхан, 2.7 мянга (16.0 хувь) нь 45-54 насныхан, 0.5 мянга (3.2 хувь) нь 55-59 насныхан, 0.2 мянга (1.0 хувь) нь 60 ба түүнээс дээш насныхан байгаа юм. Бүртгэлтэй ажилгүй иргэн өмнөх оны мөн үеэс 2.6 мянгаар буурсны 0.8 мянга (29.6 хувь) нь 15-24 насныхан, 0.9 мянга (34.1 хувь) нь 25-34 насныхан, 0.6 мянга (22.2 хувь) нь 35-44 насныхан байна.

ХҮСНЭГТ 2.5 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, насны бүлгээр, 03-р сар, сарын эцэст

Насны бүлэг	2020 он	Эзлэх хувь	2021 он		Өсөлт/Бууралт	
			Эзлэх хувь	Тоо	Хувь	
Бүгд	19 394	100%	16 775	100%	-2 619	
15-24	3 307	17.1%	2 531	15.1%	- 776	29.6%
25-34	7 431	38.3%	6 539	39.0%	- 892	34.1%
35-44	4 906	25.3%	4 324	25.8%	- 582	22.2%
45-54	2 969	15.3%	2 679	16.0%	- 290	11.1%
55-59	610	3.1%	535	3.2%	- 75	2.9%
60+	171	0.9%	167	1.0%	- 4	0.2%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны 03-р сарын эцэст бүртгэлтэй байгаа ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 0.2 мянга (1.3 хувь) нь боловсролгүй, 0.4 мянга (2.4 хувь) нь бага, 1.0 мянга (6.1 хувь) нь суурь, 8.1 мянга (48.4 хувь) нь бүрэн дунд, 1.3 мянга (7.6 хувь) нь техникийн болон мэргэжлийн, 0.8 мянга (4.8 хувь) нь тусгай мэргэжлийн дунд, 4.8 мянга (28.7 хувь) нь дипломын болон бакалаврын дээд, 0.1 мянга (0.8 хувь) нь магистр, докторын зэрэгтэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд бүрэн дунд боловсролтой иргэд 1.6 мянгаар буурсан бөгөөд нийт өөрчлөлтийн 60.9 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөр, халамжийн байгууллагад бүртгүүлсэн ажилгүй иргэн хүн хоёроор буурахад нэг нь бүрэн дунд боловсролтой иргэн байна.

**ХҮСНЭГТ 2.6 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшин, эзлэх хувиар, 03-р сар, сарын эцэст**

Боловсролын түвшин	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тогоо	Эзлэх хувь	Тогоо	Эзлэх хувь	Тогоо	Хувь
<b>Бүгд</b>	19 394	100.0%	16 775	100.0%	-2 619	-
Боловсролгүй	233	1.2%	215	1.3%	- 18	0.7%
Бага	411	2.1%	395	2.4%	- 16	0.6%
Суурь	1 146	5.9%	1 018	6.1%	- 128	4.9%
Бүрэн дунд	9 708	50.1%	8 114	48.4%	-1 594	60.9%
Техникийн болон мэргэжлийн	1 472	7.6%	1 277	7.6%	- 195	7.4%
Тусгай мэргэжлийн дунд	959	4.9%	805	4.8%	- 154	5.9%
Дипломын болон бакалаврын дээд	5 228	27.0%	4 811	28.7%	- 417	15.9%
Магистр, доктор	237	1.2%	140	0.8%	- 97	3.7%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

## АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА

Ажлын байрны захиалга 2021 оны 1-р улиралд 6.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.2 мянга буюу 15.6 хувиар буурсан дүнтэй байна. 2021 оны 3-р сард ирсэн ажлын байрны захиалга 1-р сар болон 2-р сард ирсэн захиалгаас 2.9 дахин их буюу 3.8 мянган захиалга ирсэн байна.

**ХҮСНЭГТ 2.7 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, сараар**

Сар	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тогоо	Тухайн сард нэмэгдсэн	Тогоо	Тухайн сард нэмэгдсэн	Хувь	Тогоо
<b>I</b>	2 795	2 795	1 334	1 334	-1 461	-52.3%
<b>II</b>	5 098	2 303	2 610	1 276	-2 488	-48.8%
<b>III</b>	7 595	2 497	6 413	3 803	-1 182	-15.6%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 1-р улиралд ирсэн ажлын байрны захиалгын 42.1 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбараас, 13.8 хувь нь барилгын салбараас, 7.4 хувь нь уул уурхайн, олборлолтын салбараас, 5.5 хувь нь боловсролын салбараас, 4.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбараас ирсэн байна.

Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 1.2 мянгаар буурсны 35.0 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар, 31.6 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 14.4 хувь нь боловсролын салбарт гарсан өөрчлөлтөөс шалтгаалсан байна. Өмнөх улирал буюу 2020 оны 4-р улиралд ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 22.5 хувь буурсны 50.3 хувь нь уул уурхай, олборлолт, 26.2 хувь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт гарсан

өөрчлөлтөөс шалтгаалж байсан бол 2021 оны 1-р улиралд уул уурхайн салбар өмнөх оны мөн үеэс 37 захиалгаар өссөн дүнтэй байна.

**ХҮСНЭГТ 2.8 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 03-р сар**

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	2020 он	2021 он	Өсөлт/ Бууралт
<b>Бүгд</b>	<b>7 595</b>	<b>6 413</b>	<b>-1 182</b>
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	299	108	- 191
Уул уурхай, олборлолт	439	476	37
Боловсруулах үйлдвэрлэл	464	308	-156
Барилга	873	883	10
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ	159	229	70
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	94	187	93
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	108	119	11
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	177	245	68
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	703	289	-414
Боловсрол	523	353	-170
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	337	237	-100
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3 071	2 697	-374
Бусад	348	282	- 66

*Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар*

2021 оны 1-р улиралд ирсэн ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл, 1.3 мянга (19.6 хувь) нь мэргэжилтэн, 1.1 мянга (16.9 хувь) нь энгийн ажил, мэргэжил, 1.0 мянга (16.2 хувь) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 1.1 мянга (16.7 хувь) нь худалдаа, үйлчилгээний ажилтаны захиалга байна. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 1.2 мянгаар буурсны 40.4 хувь нь мэргэжилтэн, 29.0 хувь нь энгийн ажил мэргэжлийн байна.

**ХҮСНЭГТ 2.9 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил мэргэжлийн ангиллаар, 03-р сар**

Ажил мэргэжлийн ангилал	2020 он	2021 он	Өсөлт/Бууралт	
			Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>7 595</b>	<b>6 413</b>	<b>-1182</b>	<b>100%</b>
Менежер	297	312	15	-1.3%
Мэргэжилтэн	1 736	1 258	-478	40.4%
Техникч болон туслах /дэд мэргэжилтэн	652	503	-149	12.6%
Контор, үйлчилгээний ажилтан	348	404	56	-4.7%
Худалдаа, үйлчилгээний ажилтан	1 088	1 072	-16	1.4%
ХАА, ой, загас агнуурын ажилтан	239	74	-165	14.0%
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	1 057	1 037	-20	1.7%
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	574	621	47	-4.0%
Энгийн ажил, мэргэжил	1 427	1 084	-343	29.0%
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	177	48	-129	10.9%

*Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар*

## АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН

Ажилд зуучлагдсан иргэд 2021 оны 1-р улиралд 3.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 1.4 мянга буюу 31.7 хувиар буурсан байна. 2021 оны 1-р сард ажилд зуучлагдсан иргэн 0.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.9 мянга буюу 59.1 хувь буурсан байсан бол 3-р сарын байдлаар 31.7 хувиар бага болсон байна.


### ХҮСНЭГТ 2.10 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭНИЙ ТОО, сараар

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	1 398	1 398	572	572	- 826	-59.1%
II	2 695	1 297	1 156	584	-1 539	-57.1%
III	4 489	1 794	3 066	1 910	-1 423	-31.7%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны эхний гурван сард ажилд зуучлагдсан иргэн 2019 оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байсан. Харин 2021 оны нэг болон хоёрдугаар сард ажилд зуучлагдсан иргэн 2020 оны мөн үеэс 1.4 дахин бага байгаа бол 03-р сард ажилд зуучлагдсан иргэн өмнөх оны мөн үеэс өссөн дүнтэй байна. 2021 оны 03-р сард бүх нийт хөл хориог бууруулж бизнес, ААН-ийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилсэнтэй хамааралтай байх магадлалтай юм.

### ЗУРАГ 2.3 ТУХАЙН САРД АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажилд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 38.6 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 8.6 хувь нь барилгын салбарт, 8.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 8.0 хувь нь боловсрол, 6.7 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт зуучлагдсан байна.

Ажилд зуучлагдсан иргэн өмнөх оны мөн үеэс 1.4 мянгаар буурсны 31.1 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар, 17.1 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар, 11.4 хувь нь боловсролын салбар, 9.2 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, 6.6 хувь нь уул уурхай, олборлолтын салбар бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 2.11 АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭНИЙ ТОО, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 03-р сар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	2019 он	2020 он	Өсөлт/ Бууралт
Бүгд	4 489	3 066	-1 423
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур,	233	102	- 131
Уул уурхай, олборлолт	245	151	- 94
Боловсруулах үйлдвэрлэл	305	258	- 47
Барилга	294	264	- 30
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	142	58	- 84
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	86	45	- 41
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	140	176	36
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	449	206	- 243
Боловсрол	407	245	- 162
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	235	159	- 76
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1 624	1 182	- 442
Бусад	329	220	- 109

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2021 оны 1-р улирлын байдлаар ажилд зуучлагдсан иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл, 23.2 хувь нь мэргэжилтэн, 17.9 хувь нь энгийн ажил, мэргэжил, 13.6 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 13.6 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан байна. Ажилд зуучлагдсан иргэн өмнөх оны мөн үеэс 1.4 мянгаар буурсны 28.1 хувь нь энгийн ажил мэргэжил, 17.1 хувь мэргэжилтэн, 14.5 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 12.4 хувь нь техникч болон туслах, 8.5 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан байна.

ХҮСНЭГТ 2.12 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил мэргэжлийн ангиллаар, 03-р сар

Ажил мэргэжлийн ангилал	2020 он	2021 он	Өсөлт/Бууралт	
			Тоо	Хувь
	4 489	3 066	-1 423	100%
Менежер	193	127	- 66	4.6%
Мэргэжилтэн	954	710	- 244	17.1%
Техникч болон туслах /дэд мэргэжилтэн	408	232	- 176	12.4%
Контор, үйлчилгээний ажилтан	183	202	19	-1.3%
Худалдаа, үйлчилгээний ажилтан	624	417	- 207	14.5%
ХАА, ой, загас агнуурын ажилтан	195	74	- 121	8.5%
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	494	417	- 77	5.4%
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	368	326	- 42	3.0%
Энгийн ажил, мэргэжил	948	548	- 400	28.1%
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	122	13	- 109	7.7%


Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

## ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА

2020 оны эхний улиралд ажлын байрны захиалгын 59.1 хувийг эрэлтээр хангаж байсан бол 2021 оны эхний улирлын байдлаар 6.4 мянган ажлын байрны захиалга ирсэний 3.1 мянгыг эрэлтээр хангасан байна. Нийт 47.8 хувийг эрэлтээр хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс 11.3 пунктээр бага байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуй, ой, загас барилт, ан агнуурын салбарын 94.4 хувийн, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 83.3 хувийн, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын 71.3 хувийн эрэлтийг хангасан байна.

2020 оны эхний улиралд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний салбарын ажлын захиалгын 89.3 хувийг эрэлтээр хангаж байсан бол 2021 оны эхний улиралд 25.3 хувийг эрэлтээр хангасан байна. Мөн 2020 оны эхний улиралд тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын ажлын байрны захиалгын 91.5 хувийг эрэлтээр хангаж байсан бол 2020 оны эхний улиралд 24.1 хувийг эрэлтээр хангасан байна.

ЗУРАГ 2.4 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, ЭЗҮА-ны салбарын ангиллаар, 03-р сар, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн 2021 оны эхний улирлын эрэлт, нийлүүлэлтийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл, мэргэжилтэн мэргэжлийн чиглэлээр ирсэн ажлын байрны захиалгын 56.4 хувийг, контор, үйлчилгээний ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 50.0 хувийг, ХАА, ой, загас агнуурын ажилтан чиглэлээр ирсэн захиалгын 100 хувийг, суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч ажилтан чиглэлээр ирсэн захиалгын




52.5 хувийг, энгийн ажил мэргэжлийн чиглэлээр ирсэн захиалгын 50.6 хувийг эрэлтээр хангасан байна.

2020 оны эхний улиралд менежер мэргэжлийн чиглэлээр ирсэн захиалгын 65.0 хувийг эрэлтээр хангаж байсан бол 2021 оны эхний улиралд 40.7 хувийг эрэлтээр хангасан байна. Мөн 2020 оны эхний улиралд техникч болон туслах /дэд мэргэжилтэн мэргэжлийн чиглэлээр ирсэн захиалгын 62.6 хувийг эрэлтээр хангаж байсан бол 2021 оны эхний улиралд 46.1 хувийг эрэлтээр хангасан байна.

Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан чиглэлээр ирсэн ажлын байрны захиалгын 66.3 хувийг хангаж байсан бол 2020 онд 56.5 хувь болж 9.8 пунктээр буурсан байна. Мөн 2019 онд худалдаа, үйлчилгээний ажилтан чиглэлээр ирсэн ажлын байрны захиалгын 51.6 хувийг хангаж байсан бол 2020 онд 41.9 хувь болж 9.7 пунктээр буурчээ.

ЗУРАГ 2.5 ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА, ажил мэргэжлийн ангиллаар, 03-р сар, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

### БҮЛЭГ 3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТ

Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллага, даатгуулагч болон шимтгэлийн орлого, ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэд гэх мэт хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг энэ бүлэгт авч үзнэ.

#### ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГА

2021 оны 1-р улирлын байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 46.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.4 мянга буюу 7.9 хувиар өссөн байна. Нийт шимтгэл төлөгч байгууллагын 90.1 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 9.9 хувь нь төсвийн байгууллага байна.

#### ХҮСНЭГТ 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он	Тухайн сард нэмэгдсэн	2021 он	Тухайн сард нэмэгдсэн	Өсөлт/Бууралт	
					Тоо	Хувь
I	9 692	9 692	2 815	2 815	- 6 877	-71%
II	39 687	29 995	38 631	35 816	- 1 056	-2.7%
III	42 862	3 175	46 242	7 611	3 380	7.9%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Шимтгэл төлөгч хувийн аж ахуй нэгж байгууллагын тоо 2021 оны 1-р сарын байдлаар 2.5 мянга болж өмнөх оны мөн үеэс 6.0 мянга буюу 2.5 дахин бага байсан боловч 2021 оны 03-р сарын дүнгээр 41.7 мянга болж өмнөх оны мөн үеэс 3.4 мянга буюу 8.8 хувь өссөн байна. Мөн шимтгэл төлөгч төсвийн байгууллагын тоо 4.6 мянга болж өмнөх оны үеэс өөрчлөгдөөгүй байна

#### ХҮСНЭГТ 3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОО

Сар	2020		2021		Өсөлт/Бууралт	
	Хувийн ААН	Төрийн байгууллага	Хувийн ААН	Төрийн байгууллага	Хувийн ААН	Төрийн байгууллага
I	8 493	1 199	2 459	356	- 6 034	- 843
II	35 303	4 384	34 776	3 855	- 527	- 529
III	38 286	4 576	41 668	4 574	3 382	- 2

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

#### ДААТГУУЛАГЧ

Нийгмийн даатгалд даатгуулагчид 2021 оны 1-р сард 91.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 92.7 мянга буюу 1 дахин бага байсан бол 3-р сард 845.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 13.9 мянга буюу 1.7 хувиар өссөн дүнтэй байна. Нийт даатгуулагчдын 88.1 хувь нь албан журмын, 11.9 хувь нь сайн дурын даатгуулагч бүрдүүлж байна.


#### ХҮСНЭГТ 3.3 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	Нийт даатгуулагч	Албан журмын	Хувийн ААНБ			Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо	
			Төсөвт байгууллага	Сайн дурын	Малчдын тоо		
I	91 521	50 617	24 636	25 981	40 904	4 993	4 050
II	738 140	665 503	452 416	213 087	72 637	10 488	6 295
III	845 802	744 846	503 902	240 944	100 956	18 630	8 218

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Албан журмын даатгуулагчийн тоо 2021 оны 1-р улирлын байдлаар 744.9 мянга болж өмнөх оны мөн үеэс 21.0 мянга буюу 2.9 хувиар өссөн дүнтэй байна. Тухайн сард нэмэгдсэн албан журмын даатгуулагчийн тоо 2021 оны 1-р сард 50.6 мянга болж өмнөх 2 оны мөн үеэс 2 дахин бага байсан бол 2021 оны 2-р сард өмнөх хоёр оны мөн үеэс ихээр нэмэгдсэн буюу 614.9 мянгаар нэмэгдсэн байна. Албан журмын даатгуулагчдын 67.7 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 32.3 хувь нь төсөвт байгууллагын ажиллагчид байна.

ЗУРАГ 3.1 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Хувийн аж ахуй нэгж байгууллагын даатгуулагчид 503.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 17.0 мянга буюу 3.5 хувиар, төсөвт байгууллагын даатгуулагчид 240.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.9 мянга буюу 1.7 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 3.4 АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он			2021 он		
	Нийт	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Нийт	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага
I	142 390	77 979	64 411	50 617	24 636	25 981
II	681 644	455 547	226 097	665 503	452 416	213 087
III	723 901	486 890	237 011	744 846	503 902	240 944

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагч 2021 оны 1-р улирлын байдлаар 101.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.1 мянга буюу 6.6 хувиар буурсан байна. Эхний улирлын байдлаар сайн дурын даатгуулагчдын тоо буурсан боловч нийт нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо өссөн нь зөвхөн албан журмын даатгуулагчдын тоо өссөнтэй холбоотой нь харагдаж байна. Сайн дурын даатгуулагчдын 18.5 хувь нь малчид, 8.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид бүрдүүлж байна.


ХҮСНЭГТ 3.5 САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, өсөн нэмэгдэхээр

Сар	2020 он			2021 он		
	Нийт	Малчдын тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо	Нийт	Малчдын тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо
I	41 789	10 549	6 142	40 904	4 993	4 050
II	81 302	18 993	12 273	72 637	10 488	6 295
III	108 042	25 962	16 149	100 956	18 630	8 218

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Доорх зурагт тухайн сард нэмэгдсэн сайн дурын даатгуулагчдын тоог өмнөх хоёр оны мөн үетэй харьцуулан харууллаа. 2021 оны эхний гурван сард нэмэгдсэн сайн дурын даатгуулагчдын тоо өмнөх хоёр оны мөн үед нэмэгдсэн дүнгээс бага байгаа нь харагдаж байна.

ЗУРАГ 3.2 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

**Малчид:** Сайн дураар даатгуулсан малчид 2021 оны 1-р улирлын байдлаар 18.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.3 мянга буюу 28.2 хувиар буурсан байна.

**Хувиараа хөдөлмөр эрхлэгч:** Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч 2021 оны 1-р улирлын байдлаар 8.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 8.0 мянга буюу 49.1 хувиар буурчээ. Нийт нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо өссөн боловч сайн дураар даатгуулагчдын тоо буурсан байна. Эндээс үзэхэд COVID-19 цар тахлын улмаас хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэл, үйлчилгээ нь зогссон тул сайн дураар даатгалд хамрагдах нь буурсан байна.

### ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

2021 оны 1-р улирлын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн санд 437.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна. 2019 оны мөн үеэс 57.6 тэрбум төгрөг буюу 13.2 хувь, өмнөх оны мөн үеэс 17.4 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар өссөн дүнтэй байна. Шимтгэлийн орлогын 88.0 хувийг тэтгэврийн, 5.8 хувийг тэтгэмжийн, 5.1 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, 1.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна.


ХҮСНЭГТ 3.6 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг

Сар	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тоо	Хувь
I	131.8	131.8	121.2	121.2	-10.6	-8.1%
II	271.4	139.6	264.2	143.1	-7.1	-2.6%
III	420.5	149.1	437.9	173.7	17.4	4.1%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2021 оны 1-р сард 121.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үед нэмэгдсэн орлогоос 10.6 тэрбум төгрөгөөр бага байсан бол 3-р сард 173.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үед нэмэгдсэн орлогоос 24.6 тэрбум төгрөгөөр их байна.

ЗУРАГ 3.3 ТУХАЙН САРД НЭМЭГДСЭН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны 1-р улирлын байдлаар 385.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 53.7 тэрбум төгрөг буюу 16.2 хувиар өссөн байна. Харин өмнөх улирал буюу 2020 оны 4-р улиралд нэмэгдсэн орлогоос 41.5 тэрбум төгрөгөөр их байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны 1-р улирлын байдлаар 25.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.5 тэрбум төгрөг буюу 37.9 хувиар буурсан байна. Харин өмнөх улирал буюу 2020 оны 4-р улиралд нэмэгдсэн орлогоос 10.2 тэрбум төгрөгөөр бага байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны 1-р улирлын байдлаар 22.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.9 тэрбум төгрөг буюу 43.3 хувиар буурсан байна. Харин өмнөх улирал буюу 2020 оны 4-р улиралд нэмэгдсэн орлогоос 16.3 тэрбум төгрөгөөр бага байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2021 оны 1-р улирлын байдлаар 4.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.9 тэрбум төгрөг буюу 44.6 хувиар буурсан байна. Харин өмнөх улирал буюу 2020 оны 4-р улиралд нэмэгдсэн орлогоос 4.0 тэрбум төгрөгөөр бага байна.

ХҮСНЭГТ 3.7 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, сангийн төрлөөр, тэрбум төгрөг

Сар	2020 он				2021 он			
	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүйдэл	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	Ажилгүйдэл
I	104.1	12.8	12.3	2.6	98.3	10.6	10.1	2.2
II	213.9	26.4	25.4	5.6	214.3	23.2	21.9	4.8
III	331.8	40.8	39.2	8.8	385.5	25.3	22.2	4.9

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

### АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ

Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо 2021 оны 1-р улирлын байдлаар 6.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.7 мянга буюу 31.7 хувиар өссөн байна. Харин өмнөх улирал буюу 2020 оны 4-р улирлаас 1.4 мянган хүнээр нэмэгдсэн байна. 2020 оны нэгдүгээр улирлын байдлаар сард дунджаар 1.8 мянган хүн нэмж ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж байсан бол 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар сард дунджаар 2.3 мянган хүн нэмж ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 мянган хүнээр өссөн байна.

**ХҮСНЭГТ 3.8 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВСАН ХҮНИЙ ТОО, өсөн нэмэгдэхээр**

Сар	2020 он		2021 он		Өсөлт/Бууралт	
	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тухайн сард нэмэгдсэн	Тоо	Хувь
I	2 076	2 076	2 887	2 887	811	39.1%
II	3 662	1 586	4 624	1 737	962	26.3%
III	5 268	1 606	6 938	2 314	1 670	31.7%

*Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар*

Ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 2021 оны 1-р улирлын байдлаар 13.6 тэрбум төгрөг болж, 2019 оны мөн үеэс 4.5 тэрбум төгрөг буюу 50.3 хувиар, 2020 оны мөн үеэс 0.7 тэрбум төгрөг буюу 5.1 хувиар өссөн байна. 2019 оны эхний гурван сарын байдлаар ажилгүйдлийн тэтгэмжид сард дунджаар 3.0 тэрбум төгрөг, 2020 оны эхний гурван сард дунджаар 4.3 тэрбум төгрөг, 2021 оны эхний гурван сард дунджаар 4.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан зардал өмнөх онуудаас өссөн дүнтэй байна.

**ХҮСНЭГТ 3.9 АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, сая төгрөг, өсөн нэмэгдэхээр**


Сар	2019 он	2020 он	2021 он	2019-2021		2020-2021	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
I	3 427	4 949	4 337	909	26.5%	-612.3	-12.4%
II	6 143	8 751	8 925	2 782	45.3%	174.7	2.0%
III	9 022	12 897	13 556	4 534	50.3%	659	5.1%

*Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар*

2020 оны эхний гурван сарын байдлаар нэг хүнд сард дунджаар 2.4 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмж өгч байсан бол 2021 оны эхний гурван сард нэг хүнд дунджаар 1.8 сая төгрөг зарцуулсан байна. Нэг хүнд зарцуулсан дундаж зардал өмнөх оны мөн үеэс буурсан байна.

2021 оны 1-р улиралд ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 2019 оны мөн үеэс 50.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өссөн боловч ч нэг хүнд зарцуулсан тэтгэмжийн хэмжээ 2019 оны мөн үеэс 0.2 сая төгрөгөөр нэмэгдсэн бол өмнөх оны мөн үеэс 0.4 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо өссөнтэй холбоотой юм.

**ЗУРАГ 3.4 НЭГ ХҮНД ЗАРЦУУЛСАН ДУНДАЖ ХӨРӨНГӨ, сая төгрөг, сараар**



*Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар*

#### **БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ**

2020 оны 4-р улирлаас ажиллагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурч эхэлсэн байна. Мөн 2021 оны 1-р улирлын байдлаар ажиллагчдын тоо сүүлийн зургаан жилд байгаагүй хамгийн бага түвшинд хүрээд байна. Цар тахлын тархалт нэмэгдэж олон нийтийн хөл хорио тогтоосонтой холбоотойгоор хөдөлмөр эрхэлж боломж муу болсныг харуулж байна.

Ажиллагчдын бууралт нь ажилгүй иргэдээс илүү ажиллах хүчнээс гадуурх хүн амыг нэмэгдүүлж байна. Ажиллах хүчний оролцоо буурсан байгаа нь иргэдийн ажил хайх боломж болон сонирхол буурсан байгааг харуулж байна. Мөн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа түр зогсоосонтой холбоотойгоор хүүхэд асрах шаардлага гарсан нь хөдөлмөрийн зах зээлээс гарах шалтгаан болсон байх магадлалтай.

Эхний улирлын байдлаар ажил хайгч иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 6.7 мянга буюу 21.0 хувиар буурсан байна. Мөн 3-р сард хасагдсан иргэдийн 1.9 мянга буюу 28.1 хувь нь ажилд зуучлагдсан байна. Ажил хайгч иргэд өмнөх оны мөн үеэс буурсан буюу ажил хайх сонирхол буурсаар байгааг харуулж байна. Энэ нь хөл хороотой үед гадуур явж ажил хайх боломж бага байгаа болон цэцэрлэг сургуулийн үйл ажиллагааг зогссонтой холбоотойгоор гэртээ байх шаардлагатай болсон гэж таамаглаж байна.

Ажлын байрны захиалга болон ажилд зуучлагдсан иргэд нэг болон хоёрдугаар сард өмнөх оны мөн үеэс нэг дахин бага байсан нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож байсан нь нөлөөлсөн байх. Харин гуравдугаар сард ажлын байрны захиалга 3.8 мянгаар, ажилд зуучлагдсан иргэд 1.9 мянгаар нэмэгдсэн нь олон нийтийн хөл хориог бууруулж ихэнх бизнес, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаанд явуулахыг зөвшөөрсөн нь нөлөөлсөн магадлалтай юм.

Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллагын тоо өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар, даатгуулагчдын тоо 1.7 хувиар өссөн дүнтэй байна. Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 17.4 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Даатгуулагчийн тоо 845.8 мянга болж өмнөх оны мөн үеэс 13.9 мянга буюу 1.7 хувиар өссөн боловч сайн дурын даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 7.1 мянга буюу 6.6 хувиар буурсан байна. Нийт даатгуулагчийн өсөлт нь албан журмын даатгуулагчийн өссөнтэй холбоотой юм. Тоон мэдээллээс харахад хөл хорионы улмаас хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэл, үйлчилгээ нь түр зогссон тул сайн дураар даатгалд хамрагдах нь буурсан байх магадлалтай юм.